

**Профессор Тэшигийн Мөнхжаргалын дэвшүүлсэн
“Хувийн хэрэгт хөндлөнгөөс оролцохгүй байх”
зарчим, түүний онолын үндэслэл**

**The Prof. Munkhjargal Teshig’s Principle of
Non-Interference in Personal Matters**

Ганхуягийн Давааням

Хууль зүйн ухааны доктор (LL.D.).

Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн

Хувийн эрх зүйн тэнхимийн дэд профессор

Улаанбаатар хот, Монгол Улс

davaanyam@num.edu.mn

© G.Davaanyam, 2026



[Attribution-NonCommercial 4.0 International
\(CC BY-NC 4.0\)](https://creativecommons.org/licenses/by-nc/4.0/)

[Товч утга]

Энэхүү өгүүлэл нь Монголын иргэний эрх зүйд Профессор Т.Мөнхжаргалын дэвшүүлсэн “хувийн хэрэгт хөндлөнгөөс оролцохгүй байх” зарчмыг авч үзэж, түүний онолын агуулгыг тодруулан “бие даасан байдал” (private autonomy)-ын өргөн хүрээний зарчимтай ямар холбоотой болохыг тайлбарлахыг оролдсон. Монгол Улсын иргэний хууль тогтоомж нь иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын эрх тэгш байдал, бие даасан байдал, гэрээний эрх чөлөө, өмчийн халдашгүй байдал, иргэний эрхийг шүүхээр хамгаалуулах зэрэг суурь зарчмуудыг хүлээн зөвшөөрдөг хэдий ч, социалист төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн тогтолцооны шилжилтийн үед хувийн эрх зүйн харилцаанд төрийн оролцох эрсдэл өндөр хэвээр байгаа тул “хөндлөнгөөс оролцохгүй байх” зарчим онцгой ач холбогдолтой болох талаар дурдсан.

2002 оны Иргэний хуулийн 1.2 дахь хэсэгт туссан иргэний эрх зүйн зарчмууд дотор Профессор Т.Мөнхжаргалын дэвшүүлсэн “бусдын аж ахуйн дотоод үйл ажиллагаанд хутгалдан оролцохгүй байх” гэсэн анхны томьёолол агуулгаараа туссан байна. Өөрөөр хэлбэл, аж ахуйн үйл ажиллагаа нь хуульд нийцэж байгаа тохиолдолд төр болон бусад этгээдүүд захирах, тушаах, удирдлагын шийдвэрт оролцох эрхгүй гэсэн санааг онцолсон. Өнөөгийн байдлаар Засгийн газраас төрийн болон орон нутгийн өмчит компаниудад “онцгой дэглэм” тогтоох замаар хувийн хэрэгт нь оролцож байгаа бөгөөд эдгээр нь Үндсэн хуулиар баталгаажсан хувийн аж ахуй эрхлэх эрх, түүнчлэн үндсэн эрхийн хязгаарлалтад тавигдах “тохирсон байх” (зорилгодоо нийцсэн, зайлшгүй, тэнцвэртэй байх) зарчмын үүднээс авч үзвэл хүлээн зөвшөөрөгдөхөөргүй байна.

Улмаар “хувийн хэрэгт хөндлөнгөөс оролцохгүй байх” зарчим нь хувийн эрх зүйн харилцаанд оролцогчийн үйл ажиллагааны хүрээнд төрийн оролцоог хязгаарлах хамгаалалтын чухал баталгаа бөгөөд онолын хувьд гэрээний эрх чөлөө, гэм буруугийн зарчимтай адил “бие даасан байдал” зарчмын дэд зарчим байдлаар тайлбарлан хэрэглэх боломжтой гэж дүгнэв.

[Түлхүүр үг]

Хувийн хэрэгт хөндлөнгөөс оролцохгүй байх зарчим, бие даасан байх зарчим, иргэний эрх зүйн зарчим.

Профессор Тэшигийн Мөнхжаргалын
гэгээн дурсгалд зориулав.

I. Оршил

Иргэний эрх зүйн зарчим нь хувийн эрх зүйн харилцаанд бүхий л оролцогч талуудын баримтлах тухайн нийгмийн үнэт зүйлсийг илэрхийлнэ. Монгол улсын хувьд 1992 оны Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх “хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш” байх зарчимд тулгуурлан 1993 оны Иргэний хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1-д гагцхүү “оролцогчдын эрх тэгшийн зарчим”-ыг тогтоосон байдаг.

Харин 2002 оны Иргэний хуулийн 1 дүгээр зүйлийн 1.2-д “оролцогчдын эрх тэгшийн зарчим”-аас гадна “бие даасан”, “гэрээний эрх чөлөө”, хувийн хэрэгт хөндлөнгөөс оролцохгүй”, өмчийн халдашгүй байдал”, “иргэний эрх үүргийг хязгаарлалтгүйгээр хэрэгжүүлэх”, “зөрчигдсөн эрхийг сэргээлгэх, шүүхээр хамгаалуулах” зарчмыг тус тус хуульчилсан.

Гэсэн хэдий ч, Монгол улсын иргэний эрх зүйн зарчмын талаар **нэгдүгээрт** судлаачид хооронд нэгдсэн ойлголтод хүрээгүй буюу ялгаатай байр суурийг илэрхийлж ирсэн,¹ **хоёрдугаарт** профессор Тэшигийн Мөнхжаргалын Монгол улсын иргэний харилцааны онцлогт тулгуурлан дэвшүүлж, 2002 оны Иргэний хуульд тусгалаа олсон “хувийн хэрэгт хөндлөнгөөс оролцохгүй байх” онцлог зарчмын талаар төдийлөн судлаагүй байна.

Уг судалгааны хүрээнд түүний дэвшүүлсэн Иргэний хуулийн 1 дүгээр зүйлийн 1.2 дох хэсгийн “хувийн хэрэгт хөндлөнгөөс оролцохгүй байх” зарчмын талаар Монгол улсын хувийн эрх зүйн харилцаан дахь хэрэгцээ шаардлага, хэвшиж тогтсон бие даасан байх зарчимтай уялдуулан авч үзнэ.

Иргэний эрх зүйн зарчим ба профессор Тэшигийн Мөнхжаргал багшийн дэвшүүлсэн зарчим

A. Монгол Улсын иргэний эрх зүйн зарчим

Иргэний эрх зүйн зарчим нь иргэний эрх зүйн хэм хэмжээг тогтоох, иргэний эрх зүйн харилцааг зохицуулах, эрх үүргийг

¹ 2002 оны Иргэний хууль батлагдсанаас хойш Оргийн Жамбалдорж, *Монгол улсын иргэний эрх зүй: Ерөнхий үндэслэл*, (Улаанбаатар: УБ Интерпресс, 2004). 8-н зарчим; Тэшигийн Мөнхжаргал, *Иргэний эрх зүй*, (Улаанбаатар, УБ, 2007). 5-н зарчим; Энх-Амгалангийн Байгал, *Иргэний эрх зүйн ерөнхий анги*, (Улаанбаатар, Соёмбо, 2011). 7-н зарчим; Батаагийн Тэмүүлэн, Дагвадоржийн Энхзул, Бат-Эрдэнийн Буянхишиг, *Иргэний эрх зүй*, (Улаанбаатар: Мөнхийн үсэг, 2013). 3-н зарчим; Жаргалсайханы Оюунтунгалаг, *Иргэний эрх зүй II: Гэрээний үүрэг*, (Улаанбаатар: Адмон, 2022). 7-н зарчмыг тус тус дэвшүүлсэн байна.

хэрэгжүүлэхэд мөрдлөг болгох үзэл баримтлал буюу үндсэн чиглэл, үнэт зүйлийн нийлбэр цогц юм.² Иргэний хуулийн 1 дүгээр зүйлийн 1.2-т Монгол улсын иргэний эрх зүйн зарчмын талаар “Иргэний хууль тогтоомж нь иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын эрх тэгш, бие даасан байдал, өмчийн халдашгүй байдал, гэрээний эрх чөлөө, хувийн хэрэгт хөндлөнгөөс оролцохгүй байх, иргэний эрх үүргийг ямар нэг хязгаарлалтгүйгээр хэрэгжүүлэх, зөрчигдсөн эрхийг сэргээлгэх, шүүхээр хамгаалуулах зарчимд үндэслэнэ.” хэмээн зохицуулсан.

Өөрөөр хэлбэл, Монгол улсын иргэний эрх зүй нь 2002 оны Иргэний хуулийн хүрээнд дараах зарчимд үндэслэдэг байна. Үүнд:

- 1) Эрх тэгш;
- 2) Бие даасан;
 - Гэрээний эрх чөлөө;
 - Хувийн хэрэгт хөндлөнгөөс оролцохгүй байх;
- 3) Өмчийн халдашгүй байдал;
- 4) Иргэний эрх үүргийг хязгаарлалтгүйгээр хэрэгжүүлэх³;
 - Эрх үүргээ үнэнч шударгаар хэрэгжүүлэх;
 - Хууль ёсны давуу байдлаар урвуулан ашиглахгүй байх;
 - Нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээг баримтлах;
- 5) Зөрчигдсөн эрхийг сэргээлгэх, шүүхээр хамгаалуулах;

Эдгээр зарчмуудын дотроос эрх тэгш байх, бие даасан байх, өмчийн халдашгүй байдал, иргэний эрх үүргийг хязгаарлалтгүйгээр хэрэгжүүлэх зөрчигдсөн эрхийг сэргээлгэх, шүүхээр хамгаалуулах зарчим нь үндсэн зарчим байдлаар хуульчлагдсан байна.

Харин гэрээний эрх чөлөө, хувийн хэрэгт хөндлөнгөөс оролцохгүй байх зарчим нь бие даасан байх зарчмын бие даасан зарчим, эрх үүргээ үнэнч шударгаар хэрэгжүүлэх, хууль ёсны давуу байдлаар урвуулан ашиглахгүй байх, нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээг баримтлах зарчмууд нь иргэний эрх үүргийг хязгаарлалтгүйгээр хэрэгжүүлэх зарчмын дэд зарчим хэмээн тайлбарлаж болохоор байна.

Б. Хувийн хэрэгт хөндлөнгөөс оролцохгүй байх зарчим

Профессор Тэшигийн Мөнхжаргал нь Монгол улсын иргэний эрх зүйд хоёр зарчмыг дэвшүүлсэн байдаг. Үүнд:

² Батаагийн Тэмүүлэн, Дагвадоржийн Энхзул, Бат-Эрдэнийн Буянхишиг, *Иргэний эрх зүй*, (Улаанбаатар: Мөнхийн үсэг, 2013), 16 дахь тал.

³ Оргийн Жамбалдорж, *Монгол улсын иргэний эрх зүй: Ерөнхий үндэслэл*, (Улаанбаатар: УБ Интерпресс, 2004), 60 дахь тал.

– “Бусдын аж ахуйн дотоод үйл ажиллагаанд хутгалдан оролцохгүй байх зарчим” зарчим (2000)

– “Аж ахуйн удирдлагын арга хэлбэрийг оновчтой сонгон авч, боловсронгуй болгох” зарчим (1997)

“Бусдын аж ахуйн дотоод үйл ажиллагаанд хутгалдан оролцохгүй байх зарчим” зарчим

Монгол улсын иргэний эрх зүйн зарчим дотроос “Хувийн хэрэгт хөндлөнгөөс оролцохгүй байх” зарчим нь бусад улсын иргэний эрх зүйд төдийлөн яригдахгүй, онцлог зарчим байдаг. Энэхүү зарчмыг профессор Тэшигийн Мөнхжаргал нь 2002 онд “Монгол улсын иргэний эрх зүй” бүтээлдээ “бусдын аж ахуйн дотоод үйл ажиллагаанд хутгалдан оролцохгүй байх зарчим” томьёоллоор анх удаа дэвшүүлсэн.⁴

Тэрээр “бусдын аж ахуйн дотоод үйл ажиллагаанд хутгалдан оролцохгүй байх зарчим” нь “Иргэний эрх зүйн харилцаанд оролцогчид өөрийн үйлдвэрлэл, үйлчилгээг бие дааж эрхлэхийн сацуу бусдын аж ахуйн дотоод арга, ажиллагаанд хөндлөнгөөс хутгалдан оролцохыг хориглодог. Хэрэв иргэн, хуулийн этгээд аж ахуйгаа хуулийн дагуу явуулж байгаа бол төрийн болон орон нутгийн засаглалын байгууллага, бусад ямар ч субъект хөндлөнгөөс захирах, тушаах байдлаар оролцох эрхгүй. Өөрөөр хэлбэл, эрхлэх аж ахуйн төрөл, хэлбэрийг заах бүтээгдэхүүний үнэ, өртөг, хөлсний хэмжээг тогтоох эрхгүй гэсэн ойлголт” гэжээ.⁵

“Аж ахуйн удирдлагын арга хэлбэрийг оновчтой сонгон авч, боловсронгуй болгох” зарчим

Т.Мөнхжаргал 1997 онд “Иргэний эрх зүй: ерөнхий анги” бүтээлдээ “аж ахуйн удирдлагын арга хэлбэрийг оновчтой сонгон авч, боловсронгуй болгох” зарчмыг дэвшүүлсэн байдаг.⁶ Тэрээр “аж ахуйн удирдлагын арга хэлбэрийг оновчтой сонгон авч, боловсронгуй болгох” зарчмын агуулгыг “аливаа улс оронд аж ахуйг эрхлэн хөтлөхөд амьдралаас урган гарч, тухайн эдийн засагт идэвхтэй үйлчилж чадах арга, хэлбэрийг ашиглах шаардлага зайлшгүй урган гардаг. ... Иргэний эрх зүйн субъектүүд зах зээлийн эдийн засгийн бодит амьдралыг танин мэдэж, удирдлага, зохицуулалтын арга хэлбэрийг ямар нөхцөлд хэрхэн яаж ашиглах боломжтой байна. Энэ боломж нь Иргэний эрх зүйн хэм хэмжээнд заасан байдаг” хэмээн тайлбарлажээ.

⁴ Тэшигийн Мөнхжаргал, *Монгол улсын иргэний эрх зүй: Ерөнхий анги*, (Улаанбаатар: Мөнхийн үсэг, 2000), 21 дэх тал.

⁵ *Мөн тэнд.*

⁶ Тэшигийн Мөнхжаргал, *Иргэний эрх зүй: Ерөнхий анги*, (Улаанбаатар: Эрдэм, 1997), 9 дэх тал.

Мөн Профессор Тэшигийн Мөнхжаргал нь 2002 онд “Монгол улсын иргэний эрх зүй” бүтээлдээ “аж ахуйн удирдлагын арга хэлбэрийг оновчтой сонгон авч, боловсронгуй болгох” зарчмыг хэрэгжүүлэх аргын талаар (i) төрийн удирдлагыг уламжлалт бөгөөд төлөвшиж тогтсон итгүүлэх арга ба албадах арга, (ii) захиргааны арга, (iii) эдийн засгийн арга, (iv) сэтгэл зүйн аргыг хэрэглэдэг.⁷ Улмаар захиргаа арга нь захирах, захирагдах харилцааны мөн чанар болсон засаглалын хэлбэрээр, эдийн засгийн арга нь аж ахуйн механизмын үйлчлэл буюу эрэлт нийлүүлэлтээр, сэтгэл зүйн арга нь хүмүүсийн санаа бодлоор илэрдэг гэж үзсэн.⁸

Ийнхүү түүний дэвшүүлсэн хоёр зарчмын хүрээнд судлаачид нэгдүгээрт “бусдын аж ахуйн дотоод үйл ажиллагаанд хутгалдан оролцохгүй байх” зарчмыг хүлээн зөвшөөрсөн бол хоёрдугаарт “аж ахуйн удирдлагын арга хэлбэрийг оновчтой сонгон авч, боловсронгуй болгох” зарчмыг хүлээн зөвшөөрөөгүй байдаг.⁹ Тухайлбал, судлаач О.Жамбалдорж “Аж ахуйн удирдлагын арга хэлбэрийг оновчтой сонгон авч, боловсронгуй болгох” зарчим нь “аж ахуйн удирдлагыг асуудал учраас иргэний эрх зүйн харилцааны зарчим болж чадахгүй” хэмээн шүүмжилжээ.¹⁰

Улмаар судлаачийн дэвшүүлсэн хоёр зарчмын талаар “бусдын аж ахуйн дотоод үйл ажиллагаанд хутгалдан оролцохгүй байх” зарчим нь 2002 оны Иргэний хуульд “Хувийн хэрэгт хөндлөнгөөс оролцохгүй байх” гэсэн томъёоллоор агуулгын хувьд тусгалаа олсон байна.¹¹

В. Төрөөс хувийн хэрэгт оролцож буй байдал

Профессор Тэшигийн Мөнхжаргалын дэвшүүлж, 2002 оны Иргэний хуульд туссан “Хувийн хэрэгт хөндлөнгөөс оролцохгүй байх” зарчмыг Монгол улсын иргэний эрх зүйд чухал ач холбогдолтой болохыг дараах хоёр жишээн дээр тайлбарлаж болно. Өөрөөр хэлбэл, пост-социалист улсад хамаарах Монгол улсын хувьд төрийн зүгээр хувийн эрх зүйн хуулийн этгээдийн дотоод засаглал, үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох тохиолдол байгаа нь бие даасан зарчмыг илүү тодотгосон шинжтэй “Хувийн хэрэгт хөндлөнгөөс оролцохгүй байх” зарчмын практик хэрэгцээ шаардлагыг илэрхийлж байна.

⁷ Тэшигийн Мөнхжаргал, *өмнөх эшлэл 4*, 21 дэх тал.

⁸ Тэшигийн Мөнхжаргал, *Бизнесийн эрх зүй*, (Улаанбаатар: Эрдэм, 1993), 13-14 дэх тал.

⁹ Оргийн Жамбалдорж, *өмнөх эшлэл 3*, 55 дахь тал.

¹⁰ *Мөн тэнд.*

¹¹ *Мөн тэнд.*

Засгийн газрын онцгой дэглэм

1990 оноос зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэний дараа төрийн өмчит үйлдвэрийн газарт хяналтаа хадгалах зорилгоор БНМАУ-ын Бага Хурлаас 1991 оны 1 дүгээр сарын 4-ны өдөр Засгийн газарт эрх олгох тухай хуулийг баталж, Засгийн газраас бүрэн эрхт төлөөлөгч (цаашид, БЭТ) томилох эрх зүйн орчныг бүрдүүлсэн. Уг хууль батлагдах үед шилжилтийн нөхцөл байдалтай холбоотойгоор нийтийн эрх ашгийн хамгаалах үүднээс эдийн засгийн байдлыг тогтворжуулах, хүн амын үйлчилгээний хэвийн нөхцөлийг хангах асуудал чухлаар тавигдаж байсан.¹²

Өнөөг хүртэл уг хуульд заасны дагуу Засгийн газраас ТӨБӨӨХЭ-ийн үйл ажиллагаанд онцгой дэглэмийг тогтоож ирсэн. Ялангуяа, 2019 оноос 5-н ТӨХЭ-ийн үйл ажиллагаанд онцгой дэглэм тогтоосон нь анхаарал татаж байна.

Хүснэгт 1.

Засгийн газраас ТБӨӨХЭ-д тогтоосон “онцгой дэглэм”

№	Компанийн нэр	Шалтгаан	Тогтоолын огноо	Хугацаа /сар/	Эзэмшлийн төлөв
1	“Монголросцветмет” ХХК	Хэвийн үйл ажиллагааг ханган, ТӨҮГ-ийн хэлбэрээр өөрчлөн байгуулах, санхүүгийн шалгалт хийж, ашиг сонирхлын зөрчилтэй гэрээ хэлцэлтэй холбоотой асуудлыг хууль хяналтын байгууллагаар шийдвэрлүүлэх	2019.3.6, №91	6+6=12	Тухайн үеийн төрлийн эзэмшил: 100% 100% ТӨҮГ

¹² Г.Давааням, Б.Тэлмэн, “Онцгой дэглэм ба төрийн өмчийн хяналт”, Бодлогын асуудал, 39, 2023, 2 дахь тал.

2.	“Эрдэнэт Үйлдвэр” ХХК	Хэвийн үйл ажиллагааг ханган, ТӨҮГ-ийн хэлбэрээр өөрчлөн байгуулах, санхүүгийн шалгалт хийж, ашиг сонирхлын зөрчилтэй гэрээ хэлцэлтэй холбоотой асуудлыг хууль хяналтын байгууллагаар шийдвэрлүүлэх	2019.3.6, №91	6+6=12	Тухайн үеийн төрийн эзэмшил : 51% 100% ТӨҮГ
3.	“Эрдэнэс Тавантолгой” ХК	Төлбөрийн тэнцлийн алдагдал өндөр байгаа өнөөгийн нөхцөлд гадаад валютын орох урсгалыг нэмэгдүүлж, Засгийн газрын 2022 оны №362 тогтоолыг хэрэгжүүлэх	2022.10.26, № 385 2023.04.12	6+6=12	Төрийн эзэмшил: 81.5% Хаалттай ХК
4.	“Тавантолгой” ХК	Үндсэн хуулийн 6.2-т заасан төрийн нийтийн өмч буюу байгалийн баялаг болох нүүрсний томоохон нөөц бүхий Тавантолгой орд газарт төрийн хяналтыг тогтоох	2022.12.9, № 450	6	Төрийн эзэмшил: 0% Орон нутгийн эзэмшил: 51% Нээлттэй ХК
5.	“Тавантолгой төмөр зам” ХХК	Стратегийн ач холбогдол бүхий Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын тээврийн үйл ажиллагаа, галт тэрэгний хөдөлгөөн зохион байгуулалт, хөдөлгөөний аюулгүй байдлыг мэргэжлийн удирдлагаар хангах, “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн үйл ажиллагааг хэвийн горимд шилжүүлэх	2022.12.12, № 459	6	Төрийн эзэмшил: 100% “Эрдэнэс тавантолгой” ХК-ийн охин компани

Дээрхээс харвал санхүүгийн зөрчил, ашиг сонирхлын зөрчлийн эрсдэлээс үүдэлтэйгээр төрийн болон орон нутгийн өмчит компанид онцгой дэглэм тогтоож байна.¹³ Төрийн болон орон нутгийн өмчит компанийн үйл ажиллагаа доголдож, хэвийн үйл ажиллагаа явуулах боломжгүй бол Засгийн газар өмчлөгчийн хувиар хяналт шалгалт хийж, удирдлага, зохион байгуулалтыг өөрчлөх нь зохистой.¹⁴

Гэсэн хэдий ч, онцгой дэглэм тогтоох замаар хэрэгжүүлэх аргын хувьд Үндсэн хуулийн зөрчлийг үүсгэхээр байна. Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 16.4-т иргэн нь “...хувийн аж ахуй эрхлэх эрхтэй” хэмээн заажээ. Энэхүү заалт нь өмчийн хэлбэрээс үл хамаарч, хувийн аж ахуйн үйл ажиллагаа явуулах эрх чөлөө болон хувийн аж ахуйн зохион байгуулалтын хэлбэрийг сонгох эрх чөлөөг баталгаажуулсан байна.¹⁵ Уг Үндсэн хуульд заасан үндсэн эрх нь Иргэний хууль болон Компанийн тухай хуулийн суурь үзэл санааны түвшинд тусгалаа олсон байдаг.

Төрийн зүгээс хувийн эрх зүйн харилцааны оролцогч болох компанийн хувьцааг эзэмшиж байгаа эсэхээс үл хамааран бүх төрлийн компанийн харилцаанд хувийн эрх зүйн харилцааны оролцогч болохын хувьд Иргэний хууль болон Компанийн тухай хууль нийтлэг үйлчилнэ.¹⁶ Компани нь иргэний эрх зүйн чадвар бүхий, бие даасан хувийн эрх зүйн эрх зүйн этгээд болохын хувьд өөрийн удирдлагын бүтэц буюу хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагаар дамжуулан шийдвэр гаргах замаар эрх зүйн харилцаанд оролцоно.¹⁷ Харин Засгийн газар нь онцгой дэглэм тогтоох замаар гүйцэтгэх удирдлагын эрхийг гартаа авч байгаа нь Иргэний хууль болон Компанийн тухай хуулийн суурь үзэл санаа буюу хувийн эрх зүйн харилцаанд оролцогчийн бие даасан байдал, үүнд бусад этгээд хөндлөнгөөс оролцохгүй байх зарчим нийцэхгүй.¹⁸

Ашигт малтмалын тухай хууль дахь бүрэн эрхт төлөөлөгч

Үндэсний баялгийн сангийн тухай хууль батлагдсантай холбогдуулан АМТХ-ийн 5 дугаар зүйлийн 5.7-д стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн хувьцааны эзэмшилд тавьсан хязгаарлалт тавьсан. Өөрөөр хэлбэл, АМТХ-ийн 5.7-д “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн нийт гаргасан хувьцааны 34-өөс дээш хувийг аливаа этгээд

¹³ Г.Давааням, Б.Тэлмэн, *өмнөх эшлэл 12*, 4 дэх тал.

¹⁴ *Мөн тэнд.*

¹⁵ Г.Давааням, Б.Тэлмэн, *өмнөх эшлэл 12*, 5 дахь тал.

¹⁶ *Мөн тэнд.*

¹⁷ Г.Давааням, Б.Тэлмэн, *өмнөх эшлэл 12*, 6 дахь тал.

¹⁸ *Мөн тэнд.*

дангаар болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшихийг хориглоно” хэмээн зохицуулсан. Улмаар стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн хувьцааны эзэмшилд тавьсан шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд Засгийн газар бүрэн эрхт төлөөлөгч томилохоор зохицуулсан байна.

Энэхүү АМТХ-д нэмэлтээр тусгасан Засгийн газрын БЭТ-ийн зохицуулалт нь Үндсэн хуульд заасан “хувийн аж ахуй эрхлэх” үндсэн эрх, эрх чөлөөнд харшлахаас гадна Иргэний хууль болон Компанийн тухай хууль дахь “бие даасан байдал”, үүнд бусад этгээд оролцохгүй байх буюу “хувийн хэрэгт хөндлөнгөөс оролцохгүй байх” зарчим нийцэхгүй.

Бие даасан байдлын зарчмын агуулга, түүний хүрээ

А. Бие даасан байдлын зарчим

Бие даасан байдлын зарчим (principle of private autonomy) нь Европын эрх зүйн уламжлалаас үүдэлтэй. Эрх чөлөө, эрх тэгшийн үзэл санааг хувийн эрх зүй дэх илэрхийллийг оролцогчдын бие даасан байдал хэмээн хэлж болно. Өөрөөр хэлбэл, хувийн эрх зүйн харилцааны оролцогч нь өөрийн хүсэл зоригийн үндсэн дээр өөрийн аж амьдралыг шийдвэрлэдэг.

Ромын эрх зүйд иргэд өөрсдийн гэрээ хэлцлийг чөлөөтэй байгуулах, өмчөө захиран зарцуулах эрхтэй байсан нь энэхүү зарчмын анхны илрэл байв. Харин 18 дугаар зууны төгсгөл, 19 дүгээр зууны эхээр Европт явагдсан либерал ардчилсан хөдөлгөөнүүдийн нөлөөгөөр энэхүү зарчим нь хууль тогтоомжид өргөнөөр тусаж эхэлсэн байдаг. Япон улсад энэ зарчим нь 1896 онд батлагдсан Иргэний хуулиар албан ёсоор хэрэглэгдэж, улмаар Азийн бусад улсуудад дэлгэрэх болсон. Монгол улсад энэхүү зарчим нь социалист эрх зүйн тогтолцооноос либерал ардчилсан нийгэмд шилжих үеэс буюу 1992 оны Үндсэн хуулийн дараагаар хувийн эрх зүйн хууль тогтоомжийн хүрээнд яригдах болж, 2002 оны Иргэний хуульд тусгалаа олсон байдаг.

Бие даасан байдлын зарчим нь дараах үндсэн зарчмаас бүрдэнэ. Үүнд (i) гэрээний эрх чөлөө, (ii) гэм буруугийн зарчим хамаарна.

Гэрээний эрх чөлөөний зарчим

Орчин үеийн эрх зүй нь хувь хүний амьдрал, нийгмийн харилцаа нь түүний чөлөөт хүсэл зоригт тулгуурлах ёстой гэсэн үзэл санааг баримталдаг тул гэрээний эрх чөлөөг суурь зарчмын түвшинд хүлээн зөвшөөрсөн¹⁹. Монгол Улсын иргэний эрх зүйд гэрээний эрх чөлөөний **зарчим нь гэрээний чөлөөт байдлын зарчим (freedom of contract)**

¹⁹ Жаргалсайханы Оюунтунгалаг, *Иргэний эрх зүй II: Гэрээний үүрэг*, (Улаанбаатар: Адмон, 2022), 44 дэх тал.

гэсэн нэршлийн хүрээнд хэвшин тогтож байна. Энэхүү зарчим нь гэрээний харилцаанд оролцогч нь тухайн харилцаанд орох эсэхээс чөлөөтэй шийдвэрлэх эрх чөлөөтэй байх үндсэн агуулгыг илэрнэ²⁰. Улмаар гэрээний харилцаанд орохоор шийдсэн тохиолдолд дараах гурван агуулгаас бүрдэнэ.

- Гэрээний агуулгаа чөлөөтэй сонгох;
- Гэрээний талаа чөлөөтэй сонгох;
- Гэрээний хэлбэрийг чөлөөтэй сонгох.

Гэрээний агуулгаа чөлөөтэй сонгох

Хууль тогтоомж болон нийтээр тогтсон зан суртахууны хэм хэмжээнд нийцээгүй тохиолдолд гэрээний агуулгыг талууд чөлөөтэй шийдэх эрхтэй гэсэн агуулгыг илэрхийлнэ. Гэрээний агуулгын хүрээ нь хууль тогтоомж болоод зан суртахууны хэм хэмжээний өргөн эсхүл явцуу байдлаас шалтгаалан ялгаатай байдгаараа онцлог юм.

Хууль тогтоомжоор хориглосон гэрээний агуулгын хүрээнд дараах төрлийн гэрээнүүдийг дурдаж болно.

Нэгдүгээрт Иргэний хуулийн 190.1-т заасан хуульд өөрөөр заагаагүй бол гэрээний нэг тал нь ирээдүйд бий болох өөрийн бүх эд хөрөнгийг нөгөө талын өмчлөлд шилжүүлэх, эсхүл хязгаартайгаар эзэмшүүлж, ашиглуулах /узуфрукт/-аар үүрэг хүлээсэн гэрээ;

Хоёрдугаарт Иргэний хуулийн 190.3-т заасан хувийн болон гэр бүлийн хэрэгцээний зорилгоор өөрт бэлэн байгаа бүх эд хөрөнгө, эсхүл ирээдүйд бий болох бүх эд хөрөнгөө барьцаалуулахаар үүрэг хүлээсэн гэрээ ;

Гуравдугаарт Иргэний хуулийн 191.1-т заасан иргэнд өвлөгдөх хөрөнгийн талаар гуравдагч этгээдийн хооронд байгуулсан гэрээ;

Дөрөвдүгээрт Иргэний хуулийн 202.1&202.2-т заасан нөгөө талдаа шударга бус нөхцөл тавьсан гэрээний заалт;

Тавдугаарт Иргэний хуулийн 282.2-т заасан гэрээний шударга бус хариу төлбөр ба шүүхийн эрх хэмжээ;

Харин нийтээр тогтсон зан суртахууны хэм хэмжээний хувьд эдийн засгийн харилцаанд оролцогч сул талыг хамгаалах болон нийтийн ашиг сонирхлыг хамгаалах үүднээс өргөн хүрээнд хэрэглэх боломжийг шүүхэд олгодог.

Гэрээний талаа чөлөөтэй сонгох

Гэрээний талаа чөлөөтэй сонгох нь оролцогч тухайн харилцаанд

²⁰ Оргийн Жамбалдорж, *өмнөх эшлэл 3*, 59 дэх тал; Жаргалсайханы Оюунтунгалаг, *өмнөх эшлэл 19*, 45 дахь тал; Энх-Амгалангийн Байгал, *Иргэний эрх зүйн ерөнхий анги*, (2 дахь хэвлэл), (Улаанбаатар: Соёмбо, 2011), 9 дэх тал.

орох эсэхээ чөлөөтэй шийдвэрлэх чөлөөт байдалтай агуулгын хувьд давхацна. Энэ зарчмын хэрэгжилтийн хүрээнд дараах хязгаарлалт тавигдсан байдаг.

Нэгдүгээрт иргэний эрх зүйн харилцаанд оролцогчийн 1) өдөр тутмын зайлшгүй хэрэгцээнд хамаарах ажил, үйлчилгээнээс гадна 2) нийтэд чиглэсэн ажил, үйлчилгээ үзүүлэгч этгээдэд гэрээ байгуулах үүргийг хүлээлгэх нь бий²¹. Тухайлбал, 1) өдөр тутмын зайлшгүй хэрэгцээнд хамаарах ажил, үйлчилгээний хүрээнд цахилгаан, ус суваг, тээвэрлэлт, зам, харилцаа холбоо зэрэг тодорхой нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил, үйлчилгээ эрхлэх талаар тухайн зах зээлд давамгайлж байгаа этгээд энэхүү үйл ажиллагааны хүрээнд түүнд хандсан этгээдтэй гэрээ байгуулах үүрэгтэй бөгөөд нөгөө талдаа тэгш бус нөхцөл тулган санал тавих буюу гэрээ байгуулахаас татгалзах эрхгүй (ИХ 189.4.) хэмээн заажээ²². Харин 2) нийтэд чиглэсэн ажил, үйлчилгээнд нотариатын үйлчилгээ, эмнэлгийн тусламж зэргийг багтааж болно.

Хэрэв гэрээ байгуулах үүрэг хүлээсэн этгээд гэрээ байгуулахаас татгалзсан тохиолдолд эрх зүйн үр дагаврын хувьд гэм хорын хариуцлага хүлээнэ.

Хоёрдугаарт гэрээ байгуулах тохиолдолд тодорхой этгээдтэй байгуулах үүргийг хүлээх тохиолдолд бий. Тухайлбал, Монгол Улсын хуулиар 21 нас хүрээгүй хүнд согтууруулах ундаа, тамхи худалдах, түүгээр үйлчлэхийг хориглодог бөгөөд түүнээс насны этгээдтэй гэрээ байгуулах үүргийг хүлээлгэсэн байдаг²³.

Гуравдугаарт тодорхой этгээдээс гэрээний санал авсан бол үндэслэлгүйгээр татгалзахыг хориглох нь бий. Тухайлбал, тээвэрлэлтийн гэрээний хүрээнд “зорчигч буюу ачаа, тээш тээвэрлэхийг нийтэд санал болгож байгаа этгээд нь зайлшгүй татгалзах үндэслэл байхгүй бол тээвэрлэлтийн гэрээг заавал байгуулах үүрэгтэй (ИХ 381.1) хэмээн заасан нь үүнд хамаарна.

Дөрөвдүгээрт тодорхой этгээдэд гэрээний санал гаргах үүргийг хүлээлгэсэн хуулийн зохицуулалт бий. Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа эзэмшигч өөрийн эзэмшлийн хувьцааг бусдад шилжүүлэхдээ бусад хувьцаа эзэмшигчдэд тэргүүн ээлжид санал тавих үүргийг хүлээдэг (КТХ 5.3, 5.4).

²¹ Иргэний хууль (2002)-ийн 381 дүгээр зүйл 381.1, *Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2002, №07*.

²² Батаагийн Тэмүүлэн, *Өмнөх эшлэл 3*, 59 дэх тал.

²³ Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль (2000)-ийн 7 дугаар зүйл 7.3.2, *Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2000, №06*; Тамхины хяналтын тухай хууль (2005)-ийн 6 дугаар зүйл 6.7.7, *Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2005, №27*.

Ийнхүү, гэрээний талаа чөлөөтэй сонгоход хийсэн хязгаарлалт нь тухайн харилцааны онцлогд тулгуурласан байх бөгөөд хязгаарлалтын хүрээ нь нийгмийн хэрэгцээ шаардлагатай харилцан хамааралтай байна.

Гэрээний хэлбэрээ чөлөөтэй сонгох

Гэрээний талууд байгуулах гэрээний хэлбэрийг өөрсдөө чөлөөтэй шийдэх ёстой бөгөөд хуулиар түүний хэлбэрийг тогтоосон байхыг шаардахгүй гэсэн агуулгыг илэрхийлнэ. Энэ агуулга нь гэрээний талуудын чөлөөт хүсэл зоригийг хүндэтгэхээс гадна шүүх дэх нотолгоо болон үйл баримтын үнэлгээ хөгжсөнтэй холбоотойгоор хүлээн зөвшөөрөгдсөн.

Гэвч гэрээ байгуулах хэлбэрийг хуулиар тогтоох тохиолдол бий²⁴. Үүний шалтгаан нь 1) гэрээний агуулгыг тодорхой болгож, гэрээний талуудын давуу байдал гэрээнд зүй бусаар нөлөөлөх эрсдэлийг хаах, 2) арилжааны харилцаанд тодорхой байдлыг бэхжүүлэх, эрсдэлээс сэргийлэх зэрэгт оршино. Ялангуяа, арилжаа гэрээний харилцаанд 2) дахь шалтгаан түлхүү хамаарна.

Иргэний хуульд ***нэгдүгээрт*** энгийн бичгэн хэлбэртэй гэрээ, ***хоёрдугаарт*** нотариатын гэрчлэл бүхий гэрээ, ***гуравдугаарт*** улсын бүртгэл шаардсан гэрээний төрлүүд бий. Энгийн бичгэн хэлбэртэй гэрээнд түрээсийн гэрээ(318.3), санхүүгийн түрээсийн гэрээ(313.1), барьцааны гэрээ (156.1), баталгааны гэрээ(234.2), зээлээр худалдах худалдан авах гэрээ(263.1) зэрэг гэрээний төрлүүд хамаарна. Нотариатын гэрчлэлтэй гэрээнд Иргэний хуулийн 109.2.-т заасны дагуу үл хөдлөх эд хөрөнгө шилжүүлэхэд чиглэсэн гэрээний төрлүүд хамаарна. Харин улсын бүртгэл шаардсан гэрээнд үл хөдлөх хөрөнгийн барьцаа/ипотек/ (166.1) болон үл хөдлөх хөрөнгийн түрээсийн гэрээ(318.3) орно.

Энэ хүрээнд анхаарвал зохих зүйл нь хуулиар тогтоосон гэрээний хэлбэрийн шаардлагыг зөрчсөн тохиолдолд яригдах эрх зүйн дагаврын асуудал юм. Иргэний хууль нь гэрээний чөлөөт байдлын үүднээс “төлбөр гүйцэтгэснээр өрийг хүлээн зөвшөөрсөн буюу талууд хэлэлцэн тохиролцсон бол хуульд заасан тодорхой хэлбэрээр гэрээ хийхийг шаардахгүй” (199.3) байхаар зохицуулсан. Энэ нь хуульд бичгэн хэлбэрээр байгуулахаар заасан байсан ч, талуудын чөлөөт байдлыг хүндэтгэж, гэрээ хүчин төгөлдөр байх үр дагаврын үүсгэнэ.

Харин Иргэний хуулийн тусгай ангид хуульд заасан журмыг зөрчиж, байгуулсан гэрээ хүчин төгөлдөр бус байхаар тусгайлсан заасан тохиолдолд гэрээг төгөлдөр бусад тооцож болно. Тухайлбал, **Санхүүгийн түрээсийн гэрээг бичгэн бус хэлбэрээр байгуулсан**

²⁴ Жаргалсайханы Оюунтунгалаг, *өмнөх эшлэл 19*, 55 дахь тал.

тохиолдолд хүчин төгөлдөр бус байхаар зохицуулсан байна (313.3).

Гэсэн хэдий ч шүүхийн практикт Иргэний хуулийн тусгай ангид хүчин төгөлдөр бус байхаар шууд заасан байсан ч, гэрээний чөлөөт байдлын үүднээс гэрээг хүчин төгөлдөр хэмээн дүгнэх тохиолдолд бий²⁵. Судлаачдын хувьд ч хуульд заасан хэлбэрийн шаардлагыг хангаагүй түрээсийн гэрээ хүчин төгөлдөр бус байх гэсэн Иргэний хуулийн зохицуулалт нь гуравдагч этгээдийн хувьд ач холбогдолтой бөгөөд гэрээний талуудын хувь ач холбогдолгүй” гэсэн үзэл санааг дэвшүүлэх болсон²⁶.

Гэм буруугийн зарчим

Гэм буруугийн зарчим гэдэг нь хувийн эрх зүйн харилцааны оролцогч нь гагцхүү санаатай эсхүл болгоомжгүй үйлдэл, эс үйлдэхүйн улмаас бусдад хохирол учруулсан тохиолдолд хариуцлага хүлээх агуулгыг илэрхийлдэг. Уг зарчим нь хувийн эрх зүйн харилцаанд оролцогчдын бусадтай хязгаарлалтгүйгээр эрх чөлөөг хамгаалахыг зорьдог. Өөрөөр хэлбэл, хувийн эрх зүйн харилцаанд оролцогчийн хариуцлага хүлээх үндэслэлийг тодорхой тогтоохгүй бол тэдгээрийн эрх чөлөө хумигдах эрсдэл үүснэ..

В. Хувийн хэрэг ба төрийн оролцоо

Хувийн бие даасан (**автономит**) байдал гэдэг нь хувь хүн гэрээ байгуулах, өмчөө захиран зарцуулах, харилцаанд оролцох эсэхээ өөрөө шийдэх эрх зүйн чөлөөт байдал юм. Энэ зарчим нь иргэний эрх зүйн үндсэн тулгуур ойлголт бөгөөд чөлөөт зах зээл, эрхийн тэгш байдал, гэрээний эрх чөлөөнд суурилсан нийгмийн суурийг бүрдүүлдэг.

Монгол Улсын хувьд энэхүү зарчмыг Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13, 14 дүгээр заалт болон Иргэний хуульд тодорхой тусгасан. Хувь хүн хууль зөрчөөгүй, нийгмийн ашиг сонирхолд харшлахгүй бол өөрийн хүсэл зоригт тулгуурлан харилцаанд оролцох бүрэн эрхтэй. Энэхүү хувийн эрх зүйн суурь зарчим болох хувийн бие даасан байдал нь хувь хүн, хуулийн этгээд өөрийн хүсэл зоригт тулгуурлан эрх зүйн харилцаанд чөлөөтэй оролцох боломжийг баталгаажуулдаг. Энэ нь эрх чөлөөт нийгмийн үндэс суурь бөгөөд зах зээлийн харилцааны үндсэн тулгуур хэмээн тооцогдсоор ирсэн.

Гэвч энэхүү эрх чөлөө хязгааргүй байж боломгүй. Ялангуяа

²⁵ Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдааны 2016 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 001/ХТ2016/01378 тогтоол, https://shuukh.mn/single_case/1958?daterange=2000-01-01%20-%202026-03-31&id=3&court_cat=1&bb=1 (Сүүлд үзсэн: 2026.01.18).

²⁶ Дамбын Ганхүрэл, “Монгол Улс дахь үл хөдлөх эд хөрөнгийн түрээсийн гэрээний бүртгэлтэй холбогдох хууль хэрэглээний анхаарах асуудал”, *Эрх зүй*, 60 (4), 2022, 193 дахь тал.

эдийн засаг, нийгмийн эрх тэгш бус байдал, мэдээллийн тэгш бус байдал, эрх мэдлийн төвлөрөл зэргээс үүдэн **төрөөс зохицуулалт хийх шаардлага** зайлшгүй гарч ирдэг. Гэхдээ төрийн оролцоо нь хууль ёсны чөлөөт үйлдэлд хэтэрхий гүнзгий орж, хувийн эрх чөлөөг хязгаарлах эрсдэл ч бас оршсоор байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 13 дахь заалтаар хүний эрх чөлөөг дур мэдэн хязгаарлахыг хориглосон. Үүнийг Үндсэн хуулийн төслийг БНМАУ-ын Ардын Их Хурлын 1991 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн хуралдаан дээр хэлэлцэх үед «хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур зорго байж болохгүй. Бид хуулиа эрхэмлэх, хуулиа дээдлэх эрх зүйт төрийг хэвшүүлэх гэдэг агуулгаараа энийг ойлгож болох зүйл» гэж тайлбарласан байна.²⁷

Ийнхүү төрийн оролцоо нь өөрөө хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах агуулгатай тул “тохирсон байх зарчим”-аар хязгаарлагдана.²⁸ Тохирсон байх зарчмын дагуу үндсэн эрхийн хязгаарлалт нь хууль ёсны зорилгод хүрэхэд уялдаатай, зайлшгүй, тэнцвэртэй байх гэсэн шалгуур тавигддаг.²⁹

1. Хууль ёсны зорилгод хүрэхэд уялдаатай: “Үндсэн эрхийн хязгаарлалт нь Монгол Улсын Үндсэн хуулиар хүлээн зөвшөөрсөн хууль ёсны зорилготой байх бөгөөд уг хязгаарлалт болон зорилго нь хоорондоо уялдаатай байна. Хязгаарлалт нь зорилгыг хэрэгжүүлэхэд үйлчлэх буюу чиглэсэн байхыг уялдаатай байх зарчим шаардана. Төрөөс тодорхой зорилгод хүрэхийн тулд ямар арга хэмжээ авч болохыг тодорхойлоход сонголт хийх өргөн боломжтой боловч тухайн сонголт нь тэрхүү зорилгод хүрэхэд үйлчилж, уялдсан байхын зэрэгцээ Монгол Улсын Үндсэн хуулиар тогтоосон нөхцөл, шалгуурт нийцсэн байвал зохино”.³⁰

2. Хууль ёсны зорилгод хүрэхэд зайлшгүй: “Үндсэн эрхийн хязгаарлалт нь хууль ёсны зорилгод хүрэхэд зайлшгүй байна. Зорилгод хүрэхийн тулд авч болох боломжит, үр дүнтэй арга хэмжээнүүдээс ижил үр дүнтэй боловч үндсэн эрхэд хамгийн бага халдсан арга хэмжээг нь сонгохыг энэ зарчим шаардана. Мөн зорилгын үүднээс үндсэн эрхийг хэт өргөн хүрээнд хязгаарлах, үндсэн эрхийн хэрэгжилтийг аль нэг албан тушаалтны үзэмж, дур мэдлээс хэт хамааралтай болгохоос татгалзах бөгөөд хязгаарлалт нь үндсэн эрхийн цөмийг үгүйсгээгүй

²⁷ Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 06 сарын 12-ны өдрийн 03 дугаар дүгнэлт, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17140750859751>; Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 11 сарын 22-ны өдрийн 04 дугаар дүгнэлт, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17333291452231>.

²⁸ Мөн тэнд.

²⁹ Мөн тэнд.

³⁰ Мөн тэнд.

байх, хуулийн талаарх өөр өөр тайлбаруудаас үндсэн эрхэд илүү нийцсэнийг нь хэрэглэх зэрэг агуулга үүнд хамаарна”.³¹

3. Хууль ёсны зорилгод хүрэхэд тэнцвэртэй: “Хууль ёсны зорилгыг хангаснаар хүрэх үр дүн болон хөндөгдөж буй эрхийг хэрэгжүүлэх шаардлага хоорондын тэнцвэрийг хангана. Тодруулбал үндсэн эрхийг хязгаарласнаар хангагдах ашиг сонирхол нь халдаж буй эрхийг хамгаалах ашиг сонирхлоос дээгүүр байвал тухайн хязгаарлалт нь хууль дээдлэх ёсны үүднээс зөвтгөгдөх боломжтой. Харин зорилгод хүрэх цорын ганц арга нь хэт өндөр үнээр хэрэгжих тохиолдолд тухайн аргыг хууль ёсны байсан ч ашиглаж болохгүй”.³²

Дээрхээс үзэхэд хувийн эрх зүйн харилцаанд оролцогчийн бие даасан байдлыг хязгаарлах нь Үндсэн хуулийн эрх зүй дэх тохирсон байх зарчмын үүднээс хязгаарлагдах учиртай. Ялангуяа, төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцооноос зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжсэн Монгол улсын хувьд бие даасан байдлын зарчим, түүний дотор төрийн оролцоог хязгаарлахад чиглэсэн “хувийн хэрэгт хөндлөнгөөс оролцохгүй байх зарчим” нь онцгой ач холбогдолтой байж болно.

Дүгнэлт

Иргэний эрх зүйн зарчим нь тухайн нийгмийн харилцаанд оролцогчдын баримтлах үнэт зүйлийг илэрхийлнэ. Энэ ч утгаараа нийгмийн харилцааны төсөөтэй байдлын хүрээнд адил зарчмууд яригдахаас гадна тухайн нийгмийн харилцааны онцлогоос шалтгаалан иргэний эрх зүйн ялгаатай зарчим бүрэлдэн тогтох боломжтой.

Монгол улсын хувьд 2002 оны Иргэний хуулийн 1 дүгээр зүйлийн 1.2-т “хувийн хэрэгт хөндлөнгөөс оролцохгүй байх” зарчмыг хуульчилсан нь бусад улсын иргэний эрх зүйн зарчмаас онцлог байна. Уг “хувийн хэрэгт хөндлөнгөөс оролцохгүй байх” зарчмыг профессор Тэшигийн Мөнхжаргал дэвшүүлсэн бөгөөд төрийн тогтолцоо, эдийн засгийн системийн шилжилт хийсэн Монгол улсын нийгмийн харилцааны онцлогт тулгуурласан хэмээн үзэж болно. Энэ нь Засгийн газраас хувийн эрх зүйн хуулийн этгээдэд тогтоож буй (i) онцгой дэглэм, (ii) Ашиг малтмалын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөс тусгасан уул уурхайн компанид томилох бүрэн эрхт төлөөлөгчийн жишээнээс тодорхой харагдана.

1990 онд Монгол улс төрийн тогтолцооны хувьд социалист системээс ардчилсан системд, төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжсэнтэй холбоотойгоор

³¹ Мөн тэнд.

³² Мөн тэнд.

төрийн оролцоог хязгаарлахад илүүтэйгээр анхаарах хэрэгцээ шаардлага байсан хэмээн үзэж болохоор байна. Хэдийгээр Монгол улсын хувьд улс төр, эдийн засгийн тогтолцооны шилжилтийг хууль тогтоомжийн түвшинд хийсэн боловч, тухайн шилжилт, түүний ард буй үнэт зүйл, номлол нь нийгмийн харилцааны бүхий өнцөг булан бүрд бүрэн бууж, бэхжих хүртэл хугацаа шаардагдах нь мэдээжийн зүйл юм.

Өнөөдөр ч төр, түүний байгууллага төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцооны үеийн нэгэн адилаар, шилжилтийн үеийн зохицуулалтад үндэслэн иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын өөртөө засаглах буюу хувийн хэрэгт хөндлөнгөөс оролцох байдлаар “бие даасан байдал”-д халдах үзэгдэл гарч байна. Үүнийг тод жишээг Засгийн газраас онцгой дэглэм тогтоох замаар хувийн эрх зүйн харилцаанд оролцогчийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцож байгааг дурдаж болно.

Улмаар профессор Тэшигийн Мөнхжаргалын иргэний эрх зүйн “бие даасан байдал”-ын зарчмыг агуулгыг тодруулах замаар “хувийн хэрэгт хөндлөнгөөс оролцохгүй байх” зарчмыг дэвшүүлж, одоогийн Иргэний хуулийн 1 дүгээр зүйлийн 1.2-т “бие даасан байдал” зарчмаас тусдаа агуулга бүхий зарчим байдлаар тусгасан нь онолын хувьд бүрэн хүлээн зөвшөөрч болохоос гадна практик хэрэгцээ шаардлага байгааг дурдах нь зүйтэй.

Цаашид академик ангиллын хүрээнд “хувийн хэрэгт хөндлөнгөөс оролцохгүй байх” зарчмыг “гэрээний эрх чөлөө”, “гэм буруу”-ийн зарчмын нэгэн адилаар “бие даасан байх” зарчмын агуулгыг илэрхийлсэн дэд зарчим байдлаар тайлбарлан хэрэглэж болно.

[Ном зүй]

Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2000, №06, 2000 он.

Батаагийн Тэмүүлэн, Дагвадоржийн Энхзул, Бат-Эрдэнийн Буянхишиг, Иргэний эрх зүй, Улаанбаатар: Мөнхийн үсэг, 2013 он.

Ганхуягийн Давааням, Б... Тэлмэн, “Онцгой дэглэм ба төрийн өмчийн хяналт”, Бодлогын асуудал, 39, 2023 он.

Дамбын Ганхүрэл, “Монгол Улс дахь үл хөдлөх эд хөрөнгийн түрээсийн гэрээний бүртгэлтэй холбогдох хууль хэрэглээний анхаарах асуудал”, Эрх зүй, 60 (4), 2022 он.

Жаргалсайханы Оюунтунгалаг, Иргэний эрх зүй II: Гэрээний үүрэг, Улаанбаатар: Адмон, 2022 он.

Иргэний хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2002, №07, 2002 он.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 06 сарын 12-ны өдрийн 03 дугаар дүгнэлт, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17140750859751>.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 11 сарын 22-ны өдрийн 04 дугаар дүгнэлт, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17333291452231>.

Оргийн Жамбалдорж, Монгол улсын иргэний эрх зүй: Ерөнхий үндэслэл, Улаанбаатар: УБ Интерпресс, 2004 он.

Тамхины хяналтын тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2005, №27, 2005 он.

Тэшигийн Мөнхжаргал, Бизнесийн эрх зүй, Улаанбаатар: Эрдэм, 1993 он.

Тэшигийн Мөнхжаргал, Иргэний эрх зүй: Ерөнхий анги, Улаанбаатар: Эрдэм, 1997 он.

Тэшигийн Мөнхжаргал, Монгол улсын иргэний эрх зүй: Ерөнхий анги, Улаанбаатар: Мөнхийн үсэг, 2000 он.

Улсын дээд шүүхийн 2016 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 001/ХТ2016/01378 тогтоол, https://shuukh.mn/single_case/1958?daterange=2000-01-01%20-%202026-03-31&id=3&court_cat=1&bb=1.

Энх-Амгалангийн Байгал, Иргэний эрх зүйн ерөнхий анги, 2 дахь хэвлэл, Улаанбаатар: Соёмбо, 2011 он.

[Abstract]

**The Prof. Munkhjargal Teshig’s Principle of
Non-Interference in Personal Matters**

Davaanyam Gankhuyag

Doctor of Laws (LL.D.).

*Associate Professor at the Private Law Department
School of Law, National University of Mongolia
Ulaanbaatar, Mongolia*

This article examines Professor T. Munkhjargal’s principle of non-interference in personal matters as a distinctive civil-law principle in Mongolia and clarifies its doctrinal relationship with the broader principle of private autonomy. While Mongolian civil legislation explicitly recognizes equality of participants, private autonomy, freedom of contract, inviolability of property, and judicial protection of rights, the article argues that “non-interference in personal matters” emerged as a particularly important normative response to Mongolia’s transition from a centrally planned economy to a market-based system, where the risk of administrative intrusion into private legal relations remained substantial.

The study first outlines the system of civil-law principles under Article 1.2 of the 2002 Civil Code and then reconstructs Professor Munkhjargal’s original formulation—initially expressed as the prohibition of meddling in the internal economic activities of others—emphasizing that even state and local authorities lack legitimacy to direct, command, or substitute private managerial decisions when an entity operates lawfully. The article then analyzes contemporary forms of state intervention, focusing on the government’s establishment of special regimes in state-owned or mixed-ownership enterprises and the appointment of plenipotentiary representatives. These mechanisms are assessed against constitutional guarantees of the freedom to conduct private economic activity and the requirement that any restriction of fundamental rights meets principle of proportionality (actions must be balanced, the means used must fit the goal, and the harm caused shouldn’t be excessive compared to the benefit gained).

The article concludes that the principle of non-interference should be treated as an essential normative safeguard limiting public power in private-law settings and that, doctrinally, it can be interpreted as a sub-

principle concretizing private autonomy alongside freedom of contract and fault-based liability.

[Keywords]

Principle of Non-interference in Personal Matters, Private Autonomy, Civil-Law Principles.